



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/747

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Засгийн газрын 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.8, 4.1.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, Батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх, санаачилагатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах зардалд 2.394.390 (хоёр сая гурван зуун ерэн дөрвөн мянга гурван зуун ер) төгрөгийг зарцуулж, хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орон нутагт үлдэх орлогоос гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101628

Аймгийн Засаг даргын 2018 оны 12
дугаар сарын 12-ны өдрийн 12/12 Дугаар
захирамжийн хавсралт

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭРЭЭР ОРЛУУЛАН ХААХ ИРГЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ОРОН НУТАГТ ҮЛДЭХ ОРЛООГОС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хийгдэх ажил, арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт дүн (төгрөг)	Тайлбар
1. Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах					
1	Дайчилгааны нууцын ерөөний засвар	Ком	110,890	110,890	
2	Камер болон дуу чимээ, хөдөлгөөн мэдэрдэг дохиолол дагалдах хэрэгсэлтэй нь суурилуулах ажлын хөлс	2 ком 1 ком	200,000 350,000	400,000 350,000	
3	Цонх, хаалга бүхий хаалт, хамгаалалт хийх (вакум материал)	6,85 м2	70,000	479,000	
Бүгд				1,339,890	
2. Цэргийн штабын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх					
1	2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар ирсэн ангийн захирагч нарын зочид буудлын зардал	2 хоног/ 2 хүн	211,700	211,700	
2	Сумдын ЗДТГ-ын дарга нарын сургалтын хоолны зардал	2 удаа/ 23 хүн	197,800 145,000	342,800	
Бүгд				554,500	
3. Батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх, санаачлагатай ажилласан иргэн, албан тушаалтаныг урамшуулах					
1	Жилийн ажлын үр дүнгээр эхний 3 байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газарт бэлэг, дурсгалын зүйл өгөх.	Сумдын ЗДТГ	I байр 250,000 II байр 150,000 III байр 100,000	500,000	
Нийт дүн				2.394.390	